



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/773

Булган сум

Худалдан авах ажиллагааны 2026 оны  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.

2.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, зураг төсвийг холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулан 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Гантулга), Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

3.Цахим дэлгүүрт байршсан барааг ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авалт хийхийг холбогдох байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4.Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр зохион байгуулж, үр дүн гэрээний мэдээллийг тухай бүр цахим системээр нийтэлж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газар (Б.Баярцэнгэл)-т даалгасугай.

5.Төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээний гүйцэтгэлд холбогдох хууль журам, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, зураг төсөв, гэрээний дагуу тогтмол хяналт тавьж хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), Байгаль орчны газар (А.Гантөмөр), сумын Засаг дарга нарт даалгасугай.

6.Худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-т даалгасугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР